

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН СУДАЛГАА

2026 оны 03 дугаар сарын 18

Улаанбаатар хот

Товьёог	
Удиртгал.....	2
1. Уул уурхайн салбарын үүсэл хөгжил.....	2
2. Уул уурхайн салбарын өнөөгийн байдал.....	2
2.1 Зорилго, чиглэл.....	3
2.2 Стратеги, зорилт.....	3
2.3 Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо.....	4
2.4 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь.....	4
3. Салбарын хууль, тогтоомж, бодлогын баримт бичиг.....	5
3.1 Бодлогын баримт бичиг, эрх зүйн орчин.....	5
4. Уул уурхайн салбарын экспорт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	6
4.1 Ашигт малтмалын салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.....	6
4.1.1 Гол нэр төрлийн ашигт малтмалын батлагдсан нөөц.....	6
4.1.2 Уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл.....	7
4.1.3 Газрын тосны салбарын үйлдвэрлэл.....	7
4.2 Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт.....	7
4.2.1 Экспорт, зах зээлийн эрэлт ба үнэ, орлогын өөрчлөлт.....	8
4.2.2 Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ.....	8
4.2.3 Нүүрсний экспорт.....	8
4.2.4 Зэсийн баяжмалын экспорт.....	8
4.2.5 Төмрийн хүдэр, баяжмалын экспорт.....	9
4.2.6 Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт.....	9
4.2.7 Цайрын баяжмалын экспорт.....	9
4.2.8 Молибдены баяжмалын экспорт.....	9
4.2.9 Алтны экспорт.....	9
4.2.10 Газрын тосны экспорт.....	9
4.2.11 Экспортын урсгал, логистикийн нөхцөл байдал.....	9
5. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин.....	10
5.1 Гадаадын шууд хөрөнгө оруулалт.....	10
5.2 Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ААН-ийн тоо.....	10
5.3 Гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай ААН-ийн тоо.....	11
5.4 Хөрөнгө оруулалт татаж боломжит ашигт эрдэс бүтээгдэхүүн.....	11
5.5 Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, экспортын урсгалыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд хэрэгжиж байгаа томоохон төслүүд.....	12
6. Уул уурхайн салбарын ажиллах хүчний статистик.....	12
7. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа байгаль орчинд Үзүүлж буй нөлөөлөл.....	14
7.1 Агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	14
7.2 Дуу чимээ, чичиргээний нөлөөлөл.....	14
7.3 Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	15
7.4 Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	15
7.5 Биологийн төрөл зүйлүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	15
7.6 Хог, хаягдлаас үүсэх сөрөг нөлөөлөл.....	15
Дүгнэлт.....	15
Эх сурвалж.....	17

УДИРТГАЛ

Монгол улсын эдийн засгийн бүтцэд уул уурхайн салбар стратегийн ач холбогдол бүхий тэргүүлэх салбарын нэг хэвээр байна. Тус салбар нь 2025 оны байдлаар ДНБ-ний 24-27 хувь, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 70 гаруй хувь, экспортын орлогын 90 орчим хувийг бүрдүүлж, улсын төсвийн орлогын чухал эх үүсвэр болж байна. Иймээс уул уурхайн салбарын хөгжил нь макро эдийн засгийн тогтвортой байдал, гадаад худалдааны тэнцэл, хөрөнгө оруулалтын орчинд шууд нөлөөлөх үндсэн хүчин зүйлсийн нэг юм.

Монгол улсад орчин үеийн уул уурхайн салбар 1922 онд Налайхын нүүрсний уурхайг улсын мэдэлд шилжүүлснээр эхлэл тавигдаж, улмаар 1940-өөд оноос эхлэн гадаад хамтын ажиллагаанд түшиглэсэн үйлдвэрлэлийн суурь бүрэлдэн хөгжсөн. 2025 оны байдлаар ашигт малтмалын нөөцөөр баялаг орнуудын тоонд багтаж, геологийн судалгаагаар 80 гаруй төрлийн ашигт малтмалын 6000 гаруй орд, илрэл бүртгэгдсэн нь уул уурхайн салбарын урт хугацааны хөгжлийн суурь нөхцөлийг бүрдүүлж байна.

Сүүлийн жилүүдэд зэс, нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын олборлолт, экспорт эрчимжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжих гол хүчин зүйл болж, ялангуяа нүүрс болон зэсийн баяжмалын экспорт нь гадаад валютын урсгалын үндсэн эх үүсвэрийг бүрдүүлж байгаа хэдий ч экспортын бүтэц нь цөөн нэр төрлийн түүхий эд, нэг зах зээлд хэт төвлөрсөн хэвээр байгаа нь эмзэг байдлыг бий болгож байна.

Үүний зэрэгцээ уул уурхайн салбарын хөгжил нь дэд бүтэц, логистикийн хязгаарлалт, байгаль орчны доройтол, усны нөөцийн хомсдол, орон нутгийн оролцоо зэрэг олон талт сорилттой тулгарч байна. Түүнчлэн олборлолтод түшиглэсэн эдийн засгийн бүтэц давамгайлж байгаа нь нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна.

Ийм нөхцөлд уул уурхайн салбарын өнөөгийн байдал, эдийн засагт үзүүлэх нөлөө, бодлогын орчин, тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр цаашдын хөгжлийн чиг хандлага, боломжийг тодорхойлох нь онолын болон практик ач холбогдолтой юм.

НЭГ. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Монгол Улсад орчин цагийн уул уурхайн салбар үүсч хөгжсөн түүхийг сөхвөл 1922 оноос эхлэлтэй. Тодруулбал, Монгол оронд Ардын хувьсгал ялсны дараахан буюу 1922 оны 12 дугаар сарын 25-нд шинэ тулгар Ардын Засгаас Налайхын нүүрсний уурхайг улсын мэдэлд авах шийдвэр гарсанаар уул уурхайн салбар үүсч хөгжих суурь тавигдсан. Налайхын нүүрсний газрын ашиглалтыг улсын мэдэлд авах шийдвэр гаргаснаас хойш 1940 оны сүүлчээр Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Совмонголметалл” нийгэмлэгийг байгуулснаар Монгол улсад уул уурхайн үйлдвэрлэл илүү өргөн далайцтай явагдаж, тоног төхөөрөмж, мэргэжилтэй ажиллах хүчний томоохон бааз суурь анх бүрэлдэж эхэлсэн юм.

ХОЁР. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улсын уул уурхайн салбар нь улсын эдийн засгийн тэргүүлэх салбар хэвээр байгаа бөгөөд 2025 оны байдлаар ДНБ-ийн ойролцоогоор 24-27%, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 70 гаруй хувь, экспортын орлогын 90 орчим хувийг бүрдүүлж байна. Тус салбар нь улсын төсвийн орлогын 30-35%-ийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын үндсэн эх үүсвэр болж байна. Сүүлийн жилүүдэд зэс, нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг

стратегийн ашигт малтмалын олборлолт нэмэгдэж, ялангуяа нүүрсний экспорт огцом өссөн нь эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл болж байна.

Монгол улс нь ашигт малтмалын баялаг нөөцтэй орнуудын нэг бөгөөд геологийн судалгаагаар 80 гаруй төрлийн ашигт малтмалын 6,000 гаруй орд бүртгэгдсэн байдаг. Томоохон ордуудад Оюу толгой (зэс-алт), Таван толгой (коксжих нүүрс), Эрдэнэт (зэс-молибден), Нарийн сухайт, Ухаа худаг, Багануур, Шивээ-Овоо зэрэг орд багтдаг. Зэс, нүүрсний нөөцийн хувьд Монгол улс дэлхийн чухал нийлүүлэгч орнуудын нэг гэж тооцогддог.

Экспортын бүтэц нь уул уурхайн бүтээгдэхүүнд өндөр төвлөрсөн хэвээр байна. 2025 оны байдлаар Монгол улс жилд ойролцоогоор 70-80 сая тонн нүүрс, 1.5 сая тонн орчим зэсийн баяжмал, 20 гаруй тонн алт мөн төмрийн хүдэр, жонш зэрэг бүтээгдэхүүн экспортолж байна. Экспортын 90 гаруй хувь БНХАУ-ын зах зээлд чиглэж байгаа нь зах зээлийн өндөр төвлөрөл бий болгодог. Хятадын гангийн үйлдвэрлэл, эрчим хүчний хэрэгцээ Монголын нүүрсний эрэлтэд шууд нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд салбарын хөрөнгө оруулалт голчлон томоохон төслүүд дээр төвлөрч, Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, Таван толгойн нүүрсний уурхайн өргөтгөл, мөн нүүрсний тээвэрлэлтийг дэмжих Таван толгой-Гашуунсухайт төмөр зам, Зүүнбаян-Ханги төмөр зам зэрэг дэд бүтцийн төслүүд хэрэгжиж байгаа нь экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Гэсэн хэдий ч салбар нь хэд хэдэн сорилттой тулгарч байна. Үүнд:

- Экспортын зах зээлийн хэт төвлөрөл
- Дэд бүтэц, тээвэр логистикийн хязгаарлалт
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн асуудал
- Усны нөөцийн хомсдол
- Орон нутгийн иргэдийн оролцоо, нийгмийн зөрчилдөөн

зэрэг асуудлууд багтдаг.

Байгаль орчны хувьд уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй газрын эвдрэл, тоосжилт, усны нөөцийн хомсдол нэмэгдэж байгаа нь бодлогын түвшинд анхаарал татаж, улсын хэмжээнд уурхайн ашиглалтаас үүдэн эвдэрсэн газрын хэмжээ хэдэн арван мянган гектарт хүрсэн бөгөөд нөхөн сэргээлтийн ажлыг сайжруулах шаардлага тулгарч байна.

2025 оны байдлаар уул уурхайн салбар нь эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүч хэвээр байгаа боловч зах зээлийн хэт төвлөрөл, байгаль орчны эрсдэл, дэд бүтцийн хязгаарлалт зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Ирэх жилүүдэд олборлолтоос илүү боловсруулалт, нэмүү өртөг шингээх үйлдвэрлэл, экспортын зах зээлийг төрөлжүүлэх, байгаль орчны хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нь салбарын тогтвортой хөгжлийн гол чиглэл болж байна.


2.1. Зорилго, чиглэл

Аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрдэс, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулж, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, газрын тосны боловсруулах үйлдвэрийг байгуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэхэд оршино.

2.2. Стратеги, зорилт


- Геологи, хайгуулын ажлыг нэмэгдүүлж, ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөн олборлох салбарыг эрдсийн түүхий эдээр тогтвортой хангах;
- Уул уурхайн салбарын ДНБ-нд эзлэх хувийг 30 хүртэл хувьд хүргэж, эдийн засгийн өсөлтийг хангах;
- Газрын тосны бүтээгдэхүүний импортын хамаарлыг 55 хүртэл хувиар бууруулж, бүтээгдэхүүн хангамжийн тогтвортой байдлыг хангах;
- Боловсруулах аж үйлдвэрийн ДНБ-нд эзлэх хувийг 4.9 хүртэл хувьд хүргэж, ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулж, баялгийн засаглалын сайн туршлагыг нэвтрүүлэх;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, уул уурхай, олборлолтын гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хөрөнгө оруулалтад эзлэх хэмжээг 70-аас дээш хувьд хадгалах;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааг цахимжуулах ажлыг эрчимжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааны стратегийг боловсруулах, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж чанар, аюулгүй байдлыг хангуулах.

2.3. Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо /2021-2025 он/



Эх сурвалж: АМГТГ

2.4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь /2021-2025 он/



Эх сурвалж: АМГТГ

ГУРАВ. САЛБАРЫН ХУУЛЬ, ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

3.1. Бодлогын баримт бичиг, эрх зүйн орчин

Монголын улсын уул уурхайн салбарын бодлогын орчин 2025 онд нэг баримт бичигт төвлөрөхөөс илүү олон түвшний баримт бичиг, хууль, хэрэгжилтийн хөтөлбөрөөр тодорхойлогдож байна. Урт хугацаанд “Алсын хараа-2050”, дунд хугацаанд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын хувьд Ашигт малтмалын тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, хөрөнгө оруулалтын тухай хууль зэрэг үндсэн баримт бичгийн хүрээнд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүснэгт 1. Хууль, эрх зүйн орчин /хөрөнгө оруулагчид үзүүлэх дэмжлэг/

Д/д	Хууль, эрх зүйн баримт бичиг	Зүйл/заалт	Утга (хөрөнгө оруулагчид үзүүлэх дэмжлэг)
1	Хөрөнгө оруулалтын тухай хууль	4 дүгээр зүйл	Монгол улсад хийж буй дотоод болон гадаад хөрөнгө оруулалт ижил нөхцөлөөр хамгаалагдана
2		5 дугаар зүйл	Хөрөнгө оруулалтын хэлбэрийг тодорхойлж, компани байгуулах, хувьцаа худалдан авах, нэгтгэх зэрэг боломжийг олгоно
3		11 дүгээр зүйл	Гадаад хөрөнгө оруулагч нь Монголын компанитай адил эрх, үүрэгтэй байна
4		13 дугаар зүйл	Томоохон хөрөнгө оруулалтад татварын тогтворжуулалтын гэрчилгээ олгож, татварын тогтвортой орчин бүрдүүлнэ
5		16 дугаар зүйл	Татварын бус дэмжлэг газар ашиглах эрх, дэд бүтцийн дэмжлэг, үйлдвэрлэлийн парк байгуулах боломж
6	Ашигт малтмалын тухай хууль	5 дугаар зүйл	Ашигт малтмал нь ард түмний өмч бөгөөд төр лиценз олгож ашиглуулах эрхийг хөрөнгө оруулагчдад олгоно
7		26 дугаар зүйл	Ашиглалтын тусгай зөвшөөрөл авах эрхийг тодорхойлж хөрөнгө оруулагчид орд ашиглах боломж бүрдүүлнэ
8		30 дугаар зүйл	Хайгуулын лиценз эзэмшигч нь тухайн талбайд ашигт малтмал илрүүлсэн тохиолдолд ашиглалтын лиценз авах давуу эрхтэй
9		35 дугаар зүйл	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон ашигт малтмалаа зах зээлд чөлөөтэй борлуулах эрхтэй
10	Чөлөөт бүсийн тухай хууль	11 дүгээр зүйл	Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй компаниудад татварын хөнгөлөлт олгоно
11		13 дугаар зүйл	Гаалийн татвар, НӨАТ-ын хөнгөлөлт, экспорт-импортын хялбаршуулсан журам.
12	Үйлдвэрлэл, технологийн паркийн тухай хууль	9 дүгээр зүйл	Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хөрөнгө оруулагчдад газрын болон дэд бүтцийн дэмжлэг үзүүлнэ
13		15 дугаар зүйл	Парк дотор үйл ажиллагаа явуулж буй компаниудад татварын урамшуулал олгоно
14	Татварын ерөнхий хууль	29 дүгээр зүйл	Аж ахуйн нэгжийн алдагдлыг дараагийн жилүүдэд шилжүүлэн тооцох боломж
15		30 дугаар зүйл	Хурдавчилсан элэгдэл тооцох боломж


Хүснэгт 2. Салбарын бодлогын баримт бичиг

Д/д	Бодлогын баримт бичиг	Зорилт/заалт	Утга
1	Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Зорилго 4	Эдийн засгийн өсөлтийг хангах, уул уурхайн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх
2		Зорилт 4.2	Экспортын баримжаатай уул уурхай, аж үйлдвэрийг хөгжүүлэх
3		4.2.1	Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх
4		4.2.5	Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
5		4.2.10	Уул уурхайн бүтээгдэхүүнийг дотооддоо боловсруулах үйлдвэр байгуулах
6		4.2.14	Зэс боловсруулах үйлдвэр байгуулах
7		4.2.18	Нүүрс-химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх
8		4.2.24	Геологийн судалгааг өргөжүүлж шинэ орд илрүүлэх
9	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	3.2.2	Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад оруулах
10		3.2.3	Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах
11		3.2.4	Гангийн үйлдвэр байгуулах
12		3.2.5	Нүүрс-кокс химийн үйлдвэр байгуулах
13		3.2.6	Газрын ховор элемент боловсруулах үйлдвэр хөгжүүлэх
14	Монгол улсын аж үйлдвэржилтийн бодлого	4.1	Уул уурхайн түүхий эдийг дотооддоо боловсруулах
15		4.2	Металлургийн үйлдвэр байгуулах
16		4.3	Уул уурхай, аж үйлдвэрийн кластер хөгжүүлэх

ДӨРӨВ. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ЭКСПОРТ, БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

4.1 Ашигт малтмалын салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

4.1.1 Гол нэр төрлийн ашигт малтмалын батлагдсан нөөц



Эх сурвалж: АҮЭБЯ, АМГТГ

4.1.2. Уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл

2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 95,450.6 мян.тн нүүрс, 2,126.6 мян.тн зэсийн баяжмал, 5,508.0 тн молибдены баяжмал, 13,056.8 кг алт, 8,751.9 мян.тн төмрийн хүдэр, 4,154.7 мян.тн төмрийн хүдрийн баяжмал, 571.9 мян.тн хайлуур жоншны хүдэр, 251.5 мян.тн хайлуур жоншны баяжмал, 545.7 мян.тн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна.

Д/д	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2024 он	2025 он	Гүйцэтгэлийн Хувь
1	Нүүрс	мян.тн	95,098.1	95,450.6	0.4
2	Зэсийн баяжмал ме/агуулгаар	мян.тн	1,562.2	2,126.6	36.1
3	Молибдений баяжмал ме/агуулгаар	тн	5,498.2	5,508.0	0.2
4	Цэвэршүүлээгүй алт	кг	12,594.9	13,056.8	3.7
5	Төмрийн хүдэр	мян.тн	6,642.2	8,751.9	31.8
6	Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	3,468.4	4,154.7	19.8
7	Хайлуур жоншны хүдэр	мян.тн	455.4	571.9	25.6
8	Хайлуур жоншны хүдрийн баяжмал	мян.тн	154.5	251.5	62.8
9	Цайрын баяжмал	мян.тн	552.2	545.7	-1.2

Эх сурвалж: ҮСХ

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс 352.5 (0.4%) мян.тн, зэсийн баяжмал 564.4 (36.1%) мян.тн, молибдены баяжмал 9.8 (0.2%) тн, алт 461.9 (3.7%) кг, төмрийн хүдэр 2,109.7 (31.8%) мян.тн, төмрийн хүдрийн баяжмал 686.3 (19.8%) мян.тн, хайлуур жоншны хүдэр 116.5 (25.6%) мян.тн, хайлуур жоншны хүдрийн баяжмал 97.1 (62.8%) мян.тн-оор тус тус өссөн байна.

4.1.3 Газрын тосны салбарын үйлдвэрлэл

2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3,775.1 мян.бар газрын тос үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 413.2 (9.9%) мян.бар-иар буурсан байна.



Эх сурвалж: АҮЭБЯ, АМГТГ


4.2. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт

Нийт экспорт 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15,701.5 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 81.9 (0.5%) сая ам.доллараар буурсан байна.

Үүнээс: Эрдэс бүтээгдэхүүний экспорт 14,677.1 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 111.9 (0.8%) сая ам.доллараар буурсан байна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, мөнгө, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 93.5 хувийг эзэлж байна.

4.2.1. Экспорт, зах зээлийн эрэлт ба үнэ, орлогын өөрчлөлт



Эх сурвалж: АМГТГ, ҮСХ

4.2.2. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

Д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	2024 он	2025 он	Гүйцэтгэлийн хувь
1	Чулуун нүүрс	тн/ам.дол	103.8	64.1	-38.3
2	Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,957.7	2,545.5	30.0
3	Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	79.6	72.1	-9.4
4	Цайрын баяжмал	тн/ам.дол	1,452.3	1,571.0	8.2
5	Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	232.7	176.5	-24.1
6	Молибдены баяжмал	тн/ам.дол	15,993.6	16,839.3	5.3
7	Алт	кг/ам.дол	77,233.0	115,013.0	48.9

Эх сурвалж: АҮЭБЯ

4.2.3. Нүүрсний экспорт

2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5,768.8 сая ам.долларын 90,018.2 мян.тн нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 2,929.1 (33.7%) сая ам.доллар буурсан ч, биет хэмжээгээр 6,263.4 (7.5%) мян.тн-оор өссөн байна. Нүүрсийг 100 хувь Хятад руу экспортолсон байна.

4.2.4. Зэсийн баяжмалын экспорт

2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5,808.7 сая ам.долларын 2,281.9 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 2,489.6 (75.0%) сая ам.доллар, биет хэмжээгээр 586.5 (34.6%) мян.тн-оор тус тус өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь Хятад руу экспортолсон.

4.2.5. Төмрийн хүдэр, баяжмалын экспорт

2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 634.5 сая ам.долларын 8,799.8 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 36.9 (6.2%) сая ам.доллар, биет хэмжээгээр 1,289.5 (17.2%) мян.тн-оор тус тус өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь Хятад руу экспортолсон.

4.2.6. Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт

2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 320.9 сая ам.долларын 1,818.1 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 2.4 (0.7%) сая ам.доллар, биет хэмжээгээр 449.0 (32.8%) мян.тн-оор тус тус өссөн байна. Хайлуур жоншны хүдэр, баяжмалын 89.4 хувийг Хятад, 10.3 хувийг Орос руу тус тус экспортолсон.

4.2.7. Цайрын баяжмалын экспорт

2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 234.4 сая ам.долларын 149.2 мян.тн цайрын баяжмал экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 51.1 (27.9%) сая ам.доллар, биет хэмжээгээр 23.0 (18.2%) мян.тн-оор тус тус өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь Хятад руу экспортолсон.

4.2.8. Молибдены баяжмалын экспорт

2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 99.6 сая ам.долларын 5,911.8 тн молибдены баяжмал экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 3.5 (3.6%) сая ам.доллараар өссөн ч, биет хэмжээгээр 95.3 (1.6%) тн-оор буурсан байна. Молибдены баяжмалын 88.2 хувийг Хятад, 11.8 хувийг БНСУ-руу тус тус экспортолсон.


4.2.9. Алтны экспорт

2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,240.9 сая ам.долларын 10,789.6 кг алт экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 341.6 (38.0%) сая ам.доллараар өссөн ч, биет хэмжээгээр 855.5 (7.3%) кг-аар буурсан байна. Алтны 87.4 хувийг Швейцар, 8.8 хувийг Америк руу тус тус экспортолсон.

4.2.10. Газрын тосны экспорт

2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 251.3 сая ам.долларын 3,523.0 мян.бар газрын тос экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 70.8 (22.0%) сая ам.доллар, биет хэмжээгээр 551.0 (13.5%) мян.бар-иар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь Хятад руу экспортолсон.

4.2.11. Экспортын урсгал, логистикийн нөхцөл байдал



Эх сурвалж: ГЕГ, ҮСХ

ТАВ. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

5.1. Гадаадын шууд хөрөнгө оруулалт /жилээр, хувь/



Эх сурвалж: Монгол банк

5.2. Гадаадын 100% хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо /хөрөнгө

оруулагч улсаар, 2025 он/

Д/д	Улс	Эзэмшигчийн тоо	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбай	
				Га	Хувь
	БҮГД	285	442	1,260,176.6	100
1	Хятад	180	249	672,503.56	53.37
2	Виржиний Арлууд	22	39	63,195.35	5.01
3	Хонг-Конг	16	35	85,688.70	6.80
4	Канад	12	19	198,443.14	15.75
5	Сингапур	11	32	102,546.42	8.14
6	Өмнөд Солонгос	7	7	10,349.62	0.82
7	Австрали	4	7	28,244.16	2.24
8	Орос	4	4	2,303.98	0.18
9	Америкийн Нэгдсэн Улс	3	6	8,234.37	0.65
10	Их Британи	3	4	6,038.72	0.48
11	Люксембург	2	6	13,528.21	1.07
12	Голланд	2	9	28,664.94	2.27

13	Герман	2	2	603.89	0.05
14	Япон	2	3	3,015.13	0.24
15	Малайз	1	2	2,416.53	0.19
16	Казахстан	1	1	136.46	0.01
17	Австрали, Хятад	1	3	8,795.36	0.70
18	Швейцарь	1	2	192.50	0.02
19	Фижи	1	1	2,325.21	0.18
20	Фароегийн Арлууд	1	1	1,275.22	0.10
21	Украин	1	1	8,136.53	0.65
22	Сейшелс	1	1	375.18	0.03
23	Орос, Хятад	1	1	47.50	0.00
24	Болгар	1	1	3,700.94	0.29
25	Канад, Сингапур	1	2	6,977.26	0.55
26	Их Британи, Хятад	1	1	54.23	0.00
27	Ирланд, Их Британи	1	1	331.41	0.03
28	Виржиний Арлууд, Сингапур	1	1	1,933.96	0.15
29	Орос, Өмнөд Солонгос	1	1	118.15	0.01


Эх сурвалж: АМГТГ

5.3. Гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо /хөрөнгө оруулагч улсаар, 2025 он/

Д/д	Улс	Эзэмшигчийн тоо	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбай	
				Га	Хувь
	БҮГД	88	146	310529.46	100
1	Монгол-Хятад	39	56	77593.2	24.99
2	Монгол, Сингапур	9	24	36739.53	11.83
3	Монгол, Өмнөд Солонгос	9	13	26831.01	8.64
4	Монгол, Орос	8	11	3660.89	1.18
5	Монгол, Виржиний Арлууд	6	8	27724.22	8.93
6	Монгол, Япон	5	13	45351.13	14.60
7	Монгол, Хонг-Конг	2	7	23454.23	7.55
8	Монгол, Герман	2	3	5748.07	1.85
9	Монгол, Люксембург	1	2	10011.16	3.22
10	Монгол, Чехийн Бүгд Найрамдах Улс	1	1	86.29	0.03
11	Монгол, Хонг-Конг, Япон	1	3	43809.33	14.11
12	Монгол, Унгар	1	1	87.42	0.03
13	Монгол, Польш	1	1	1561.28	0.50
14	Монгол, Орос, Украин	1	1	46.87	0.02
15	Монгол, Канад, Хятад	1	1	6352.79	2.05
16	Монгол, Их Британи	1	1	1472.04	0.47

Эх сурвалж: АМГТГ

5.4. Хөрөнгө оруулалт татах боломжит ашигт эрдэс бүтээгдэхүүн



Эх сурвалж: АҮЭБЯ, ҮСХ

5.5. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, экспортын урсгалыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд хэрэгжиж байгаа томоохон төслүүд

Д/д	Төслийн нэр	Төрөл	Хүчин чадал	Тайлбар
1	Таван толгой-Гашуунсухайт төмөр зам	Тээвэр, логистик	233.6 км 30-50 сая тн/жил	Нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, тээврийн зардал бууруулах
2	Зүүнбаян-Ханги төмөр зам	Тээвэр, логистик	226.9 км 20 сая тн/жил	Зүүн чиглэлийн экспорт нэмэгдүүлэх
3	Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам	Тээвэр, логистик	32.6 км 30-40 сая тн/жил	Нүүрсний экспортын урсгалыг нэмэгдүүлэх
4	Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам	Тээвэр, логистик	400 км	Зүүн бүсийн ашигт малтмалын экспортыг дэмжих
5	Гашуунсухайт-Ганцмод боомт	Хил, логистик	40 сая тн/жил	Монгол-Хятад гол нүүрсний гарц
6	Ханги, Бичигт боомтын хөгжил	Хил, логистик	20-25 сая тн/жил	Экспортын шинэ гарц нээх
7	Зэс хайлуулах, боловсруулах үйлдвэр	Үйлдвэрлэл	530 мян.тн баяжмал/жил 125 мян.тн катод зэс	Дотооддоо баяжмал боловсруулах, хүхрийн хүчил дагалдах бүтээгдэхүүн гаргах
8	Нүүрс баяжуулах үйлдвэр /Таван толгой/	Үйлдвэрлэл	10-30 сая тн/жил	Нүүрсний чанарыг сайжруулж, экспортын орлогыг өсгөх
9	Алт цэвэршүүлэх үйлдвэр	Үйлдвэрлэл	20 тн алт/жил	Монгол банкны валютын нөөцийг нэмэгдүүлэх
10	Дарханы төмөрлөгийн үйлдвэр /өргөтгөл/	Үйлдвэрлэл	100 мян.тн ган/жил 2.5 сая тн баяжмал	Дотоодын төмрийн хүдрийг бүрэн боловсруулах
11	Газрын тос боловсруулах үйлдвэр	Үйлдвэрлэл	1.5 сая тн/жил	Түлшний импортын хамаарлыг бууруулах

Уул уурхайн салбарт хэрэгжиж буй төмөр зам, боомт, боловсруулах үйлдвэр зэрэг дэд бүтэц, логистикийн төслүүд бүрэн хэрэгжсэнээр Монгол улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдэж, тээвэрлэлтийн хугацаа болон зардал буурах боломж бүрдэнэ. Авто тээврээс төмөр замын тээвэрт шилжих нь логистикийн үр ашгийг сайжруулж, хил боомтын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ экспортын шинэ коридоруудыг бий болгоно. Мөн ашигт малтмалыг дотооддоо боловсруулах үйлдвэрүүд байгуулагдсанаар түүхий эдийн экспортоос өндөр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл бүрдэж, аж үйлдвэрийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.


ЗУРГАА. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СТАТИСТИК

Монгол улсын уул уурхайн салбар нь 2025 оны байдлаар нийт 72,285 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Ажиллах хүчний дийлэнх нь өмнөд болон төвийн бүсэд, томоохон орд газрууд байрлах Өмнөговь, Орхон аймгуудад төвлөрсөн бөгөөд нийт ажиллагсдын 75-85 хувийг бүрдүүлж байна. Салбарын бүтэц нь хувийн хэвшил давамгайл, техник тоног төхөөрөмжийн оператор, инженер, техникийн ажилтнууд зонхилсон


онцлогтой. Хангай, хойд болон баруун бүсүүдэд алт болон жижиг, бичил уурхайн үйл ажиллагаа харьцангуй бага хэмжээгээр тархсан байна.



Эх сурвалж: АМГТГ



Эх сурвалж: АМГТГ





ДОЛОО. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ

Уул уурхайн салбарын үйл ажиллагаа нь геологи хайгуулын ажлын шатнаас эхлээд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж эхэлдэг ба ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын явцад сөрөг нөлөөллийн хэмжээ нэмэгддэг.



7.1. Агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад өрөмдлөг, хайгуулын зориулалттай уулын ажил, уурхайн хөрс хуулалт, олборлолт, овоолгын ажлууд, далд уурхайн нэвтрэлтийн ажлууд, технологийн тээвэрлэлт, гадаад дотоод тээвэр, логистик, үйлчилгээний ажлууд гээд маш олон тооны техник, тоног төхөөрөмжийн хүчээр хийгддэг ажлуудын явцад техникийн утаа, тэдгээрийн хөдөлгөөнөөс шалтгаалан үүсэх тоос зэрэг нь орчны агаар мандалыг бохирдуулдаг. Бохирдсон агаар нь тухайн орчинд ажиллаж, амьдарч буй иргэд, мал амьтны амьсгал, эрүүл мэндэд нөлөөлөхөөс гадна салхины аясаар зөөгдөж, бэлчээр ургамал, усны эх үүсвэр зэрэгт ч нөлөөлж байдаг.

7.2. Дуу чимээ, чичиргээний нөлөөлөл

Уул уурхайн үйлдвэрлэл, төслийн талбайд ажиллаж байгаа машин, тоног төхөөрөмжийн үүсгэж байгаа элдэв дуу чимээ болон уурхайн олборлолтын явцад хийгддэг

ерөмдлөг, тэсэлгээний ажлаас их бага хэмжээний чичиргээ, доргион үүсэх нь хүн, амьтны сонсгол эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үүсгэдэг.

7.3. Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад газрын гадаргуугийн болон газрын гүний усны нөөц, түүний урсац хэсгүүд өртөх тохиодол байнга гардаг бөгөөд энэ нь усны нөөцөд их бага хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлдэгээс гадна уул уурхайн ашиглалт, боловсруулалтын технологийн хэрэгцээнд багагүй хэмжээний ус зарцуулагддаг нь усны нөөцийг багасгах, бохирдуулах сөрөг нөлөөллийг үзүүлдэг.

7.4. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уул уурхайн үйлдвэрлэл нь дэлхийн чулуулаг бүрхүүл, газрын хэвлийтэй харьцдаг үйлдвэрлэл учраас чулуулаг бүрхүүлийг хучиж буй хөрс, ургамалыг гэмтээх замаар шууд сөргөөр нөлөөлдөг. Мөн их, бага хэмжээний уурхайн ухшуудыг үүсгэхээс гадна тодорхой хэмжээний талбайг хөрсний болон хаягдал чулуулгийн овоолгоор дарж, ашиглалтгүй болгох нөлөөлөл ч байдаг.

7.5. Биологийн төрөл зүйлүүдэд үзүүлэх нөлөөлөл

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд биологийн зарим нэг төрөл зүйлүүд өртөх нь цөөн биш байна. Үүнд ургамал, ойн талбай хөндөгдөх, зарим амьтдын амьрах орчин хязгаарлагдах, оршин буй газраасаа нүүдэллэх, дайжих зэргээр сөрөг нөлөөлөлд өртдөг.

7.6. Хог, хаягдлаас үүсэх сөрөг нөлөөлөл

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагааны явцад ахуйн төрөл бүрийн хог хаягдлаас гадна техник, технологийн гаралтай хог хаягдал их хэмжээгээр гарч байгаль орчин, газар нутгийг бохирдуулдаг. Үүнд цаас, даавуу, хуванцар, төмөр, модны, хоолны хаягдал, элдэв химийн бодис, шатах тослох материалын хаягдал, асгаралтаас гадна аккумулятор, резин дугуй, бусад резин эдлэл зэрэг багтана.

Дээр дурьдсан сөрөг нөлөөллийг бууруулах багасгах талаар уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хэмжээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны нөхөн сэргээлийн төлөвлөгөө, биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, хог хаягдлын менежментийн зохион байгуулалт, төлөвлөгөө, уурхайн хаалтын төлөвлөгөө зэрэг маш олон тооны бичиг баримт, стандартуудыг боловсруулан мөрдөхийн дээр олон тооны зааварчлагаа, урьдчилан сэргийлэх санамжуудыг үйл ажиллагаандаа хэрэглэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, аль болох бага нөлөөлөлтэй болгох талаар идэвхитэй, тодорхой ажиллаж байгаагийн дээр байгаль орчны хяналт, мониторингийн олон төрлийн ажил, шинжилгээнүүдийг тогтмолжуулан ажиллаж, олон улсын туршлага, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын уул уурхайн салбар нь эдийн засгийн өсөлтийн үндсэн хөдөлгөгч хүч хэвээр байгаа бөгөөд ДНБ, экспорт, төсвийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлж, макро эдийн засгийн тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлж байна. Ашигт малтмалын нөөц, томоохон ордууд нэмэгдэж буй олборлолт нь салбарын урт хугацааны хөгжлийн суурь нөхцөлийг хангаж байна. Сүүлийн жилүүдэд нүүрс, зэс, алт зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт, экспорт өсөж, ялангуяа зэсийн экспортын орлого эрчимтэй нэмэгдэж байгаа нь

салбарын бүтцэд тодорхой өөрчлөлт авчирч байна. Гэсэн хэдий ч экспортын бүтэц цөөн төрлийн түүхий эдэд төвлөрсөн, нэг зах зээлээс өндөр хамааралтай хэвээр байгаа нь эдийн засгийн эмзэг байдалд хүргэж байна. Нөгөө талаас уул уурхайн салбар нь дэд бүтэц, логистикийн хязгаарлалт, байгаль орчны доройтол, усны нөөцийн хомсдол, орон нутгийн оролцооны асуудал зэрэг олон талт сорилттой тулгарч байна. Ялангуяа байгаль орчны нөлөөлөл нь газрын эвдрэл, агаарын бохирдол, усны хомсдол зэрэг хэлбэрээр илэрч, тогтвортой хөгжлийн бодлогыг улам бүр чухал болгож байна .

Цаашид уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангахын тулд олборлолтод суурилсан загвараас боловсруулалт, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлд шилжих, экспортын зах зээлийг төрөлжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчны хариуцлагатай менежментийг сайжруулах шаардлагатай байна. Мөн баялгийн засаглалыг боловсронгуй болгож, хөрөнгө оруулалтын орчныг тогтвортой байлгах нь салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чухал нөхцөл болно.

Иймээс уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засгийн тулгуур хэвээр байх боловч урт хугацаанд тогтвортой, олон тулгуурт эдийн засгийг бүрдүүлэх зорилгоор бүтэц, бодлого, менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэх шаардлагатай тулгарч байна.

Эх сурвалж:

1. Ашигт малтмалын тухай хууль (шинэчилсэн найруулга)-2006
2. Хөрөнгө оруулалтын тухай хууль-2013
3. Татварын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)-2019
4. Чөлөөт бүсийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-2015
5. Үйлдвэрлэл, технологийн паркийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-2022
6. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
7. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
8. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /2014-2025 он/
9. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам /Салбарын 2024-2025 оны тайлан/
10. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам /Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл-2025/
11. Байгаль орчин, аялал жуулчлалын яам /Нөхөн сэргээлтийн тайлан/
12. Ашигт малтмал, газрын тосны газар /Монгол улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны судалгаа 2025/
13. Ашигт малтмал, газрын тосны газар /Эрдэс баялгийн статистик мэдээ-2025/
14. Монгол банк /Уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтад нөлөөлөх эрсдэлийн хүчин зүйлийн шинжилгээ/
15. Монгол банк /Уул уурхайн ба уул уурхайн бус салбарын хоорондын хамаарлыг судлах нь/
16. Гаалийн ерөнхий газар /Гадаад худалдааны статистик-2025/
17. Н.Даваасамбуу МУ-ын зөвлөх инженер, доктор (Ph.D) /Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжил, байршлын төлөвлөлтийн судалгаа/
18. SGIS /Уул уурхайн салбарын судалгаа-2025/
19. Mongolian Mining Journal. Mining Sector Review, 2024-2025